



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

Хичээлийн хэрэгслийн багц
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.6, хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Тус дүүргийн тусламж, дэмжлэг шаардлагатай болон олон хүүхэдтэй өрхийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгслийн багц олгох ажлыг зохион байгуулсугай.
- 2.Багц авахад шаардлагатай хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.
- 3.Хичээлийн хэрэгсэл авахад шаардагдах 1,850,000 (нэг сая найман зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 08 сарын 28-ны өдрийн 1141 дугаар
захирамжийн хавсралт



ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГСЛИЙН БАГЦ АВАХАД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хичээлийн хэрэгслийн багц	ш	20	92,500	1,850,000
Дүн					1,850,000